



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.06.19 № 03/1243

танай _____-ны № _____-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зарласан НХААГ/20240101314 дугаартай Бүгд Найрамдах Франц Улсын нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэж байгаа “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн 2 дугаар шугам буюу “Яармаг, Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хархорин захын автобусны буудал” чиглэлийн хоёр зогсоол болон зарим тулгуур багануудын гадна тохижилт, зураг төсөл, инженерийн дэд бүтцийн ажилд тендер шалгаруулалттай холбоотой оролцогчоос гомдол гарсан.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гомдлыг хянан үзээд тус тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх шийдвэр гаргасан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу тендерийн хүлээн авах эцсийн хугацааг сунгаж байна. Үүнд:

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд:

- ТШЗ 26.1: Тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэл.
- ТШЗ 26.2: Тендер нээх хугацааг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 09 цаг 30 минут хүртэл болгон өөрчилснийг мэдэгдэж байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.